



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/208

Алтай хот

Тусгай зөвшөөрөл олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээнд тавигдах шаардлагыг хангаж, спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаагаар худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахаар материалаа ирүүлсэн аж ахуйн нэгжийг хавсралтаар баталсугай.

2.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хууль тогтоомж, шаардлага журмыг зөрчсөн тохиолдолд зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авч ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар), Цагдаагийн газар (Н.Эрдэнэ-Очир), холбогдох сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2014 оны
05 дугаар сарын 14-ны өдрийн 1408 дугаар
захирамжийн хавсралт

СПИРТИЙН ӨНДӨР БОЛОН СУЛ АГУУЛАМЖТАЙ
СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАСАН АЖ АХУЙН НЭГЖҮҮД

Д/д	Сумын харьяалал	Аж ахуйн нэгжийн нэр	Дэлгүүр, үйлчилгээний газрын нэр	Байрлал	Худалдаа үйлчилгээний хэлбэр
1.	Есөнбулаг сум	"Цагаан-Өлгий" ХХК	Номгон хүнсний дэлгүүр	Түмэн баг	Худалдах
2.	Есөнбулаг сум	"Баяжих халиун" ХХК	МН хүнсний дэлгүүр	Түмэн баг	Худалдах
3.	Есөнбулаг сум	"Нам нуруу" ХХК	Баян-Уул хүнсний дэлгүүр	Баяншанд баг	Худалдах
4.	Есөнбулаг сум	"Нүнжиг хангай хархираа" ХХК	Тайшир хүнсний дэлгүүр	Жаргалант баг	Худалдах
5.	Есөнбулаг сум	"Баян ёлын ам" ХХК	Баялаг хүнсний дэлгүүр	Жинст баг	Худалдах
6.	Есөнбулаг сум	"Ээвийн гол" ХХК	Далан ээв караоке	Оргил баг	Үйлчлэх
7.	Есөнбулаг сум	"Их шандын ханан" ХХК	Ундарга хүнсний дэлгүүр	Харзат баг	Худалдах